

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2019.01.24-2019.02.25/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын харьяалалгүй ахмад настнуудыг аж ахуйн нэгж байгууллагад харьяалуулах ажлыг зохион байгуулж Сумын хэмжээнд нийт 242 ахмад настнаас 201 ахмад настан буюу 83%-ийг суманд үйл ажиллагаа явуулдаг 40 аж ахуйн нэгж, байгууллагад харьяалуулж, харьяалалгүй 41 ахмад настныг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын хүндэтгэлд хамруулан хүндэтгэл үзүүлсэн.



2-р багийн малчин Ч.Баттогтох "Аймгийн аврага" малчнаар тодорч аймаг, сумын удирдлагууд 2019 оны 01-р сарын 31-ний өдөр гэрт нь шагналын гардууллаа.



Сар шинийн хүчит бөхийн барилдаан 2019 оны 02 сарын 02-ны өдөр зохион байгуулагдаж аймгийн харцага А.Тулга түрүүлж, аймгийн заан Б.Амартөр үзүүрлэн аймгийн арслан Л.Амаржаргал, аймгийн начин Б.Мөнхдорж нар шөвгөрсөн байна.



Сар шинийн нийтийн золголтын үйл ажиллагааг 02-р сарын 05-нд зохион байгуулж сумын “Хүндэт иргэн”-ээр өндөр настан Ч.Гомбо, сумын “Хүндэт Өргөмжлөл”-өөр Г.Төгсжаргал, сумын “Сайн малчин”-аар Ц.Дэжид, Б.Хашхүү, Т.Баттөмөр, сумын “Алдарт уяач”-аар Д.Базарсүрэн, Ш.Лхамсүрэн, сумын “Мянгат малчин”-аар Д.Бадамцэцэг, Н.Ганзориг нар тус тус шагнагдлаа.



Сумын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж албан байгууллагуудын мэдээлэлтэй танилцан байгууллагуудын удирдлагуудад холбогдох чиглэлийн дагуу хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.



2018-2019 оны хичээлийн жилийн II улирал дуусахтай холбогдуулан “Үдийн цай”-ны үйл ажиллагаа явуулдаг Сүмбэр Шүтээн ХХК-д хөндлөнгийн хяналт хийхэд үдийн цайны үйл ажиллагаа 90,3%-иар үнэлэгдэж хамтран ажиллах гэрээг сунгасан.

СОЁЛЫН ТӨВ



“Соёлын довтолгоо” монголын уран сайханы шинэ киног суманд авчран 2 сарын 12-нд иргэд, хөдөлмөрчид болон хүүхэд багачууддаа үзүүллээ.

“Гэгээн хайрын баяр”-ыг тохиолдуулан 2 дугаар сарын 14-нд үдшийн цэнгүүнийг зохион байгуулж Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан О. Алтанхүү, дуучин С. Лхагвадорж нар ая дуугаа өргөлөө. Мөн цэнгүүнд хүрэлцэн ирсэн хосууд болон залуучуудынхаа дунд хөгжөөнт тоглоомыг зохион байгуулж амжилттай оролцож Тэргүүн байрыг эзэлсэн хосууддаа “Өргөмжлөл”, гарын бэлгээр урамшуулахаас гадна 2019 оны турш соёлын төвөөс зохион байгуулж байгаа урлаг, соёлын арга хэмжээнд үнэ төлбөргүй хамрагдах “Эрхийн бичиг”-ээр шагнаж урамшууллаа.



Сумын албан байгууллагуудын дунд Монголын уламжлалт шагайн наадгайн тэмцээнийг багийн мэндчилгээ, шагай хамах, алаг мэлхий, 7 шагай түүх, морь уралдах, сээр хугалах, уран бэрийн шалгуур гэсэн 7-н төрлөөр зохион байгуулж нийт 6 баг оролцон нийлбэр оноогоор 1-р байрыг Ерөнхий боловсролын сургууль, 2-р байрыг Засаг даргын Тамгын газар, 3-р байрыг 3-р цэцэрлэгийн багууд тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.




3-Р ЦЭЦЭРЛЭГ

2 дугаар сард цэцэрлэгт өдрийн дунджаар 170-190 хүүхэд хамрагдаж байна. 21-р зөрлөгийн салбар бүлэгт 12 хүүхэд хамрагдаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын “Цөм” хөтөлбөрийн хүрээнд бага, дунд бүлэгт “Тоглонгоо хөгжих” сургалтын технологийн хүрээнд “Бяцхан тогооч” сэдвээр, ахлах, бэлтгэл бүлэгт “Боржигон нутаг бидний бахархал” сэдвээр төсөлт тоглоомоор үйл ажиллагаагаа явагдаж байна. Боржигон нутаг бидний бахархал сэдвийн хүрээнд боржигон байшингийн онцлогийг бага насны хүүхдэд танилцуулж байна.

3-р цэцэрлэг нь ариун цэврийн өрөө болон гал тогоондоо халаагчтай усны цорго суурилуулсан. Мөн хүүхэд бүрийн хөгжлийг хангах хөгжмийн боловсролыг хөгжүүлэх

зорилгоор бага гарын ятга 4, шигшүүр 10 хос, дуут хөгжим 5, хонх 10, цохилуурт халбага 20 ширхэгийг авч хөгжмийн энгийн зэмсэгийн тоог нэмэгдүүлээд байна.



оролцож **Тэргүүн** байр эзэлсэн.

БСУГазар, аймгийн 6-р цэцэрлэгтэй хамтран аймгийн бүх СӨБ-ын дунд зохион байгуулсан “Багшийн хөгжил хамтын ажиллагаа” сэдэвт уралдааны хүрээнд багшийн хөгжил төв болон СӨБ-ын багш нарын авьяас, хууль эрх зүйн мэдлэгийг сорьсон 3 төрлийн тэмцээнд амжилттай

STEAM сургалтын технологийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор аймгийн “Сансар” цэцэрлэгийн багш нарт 3-р цэцэрлэгийн багш нар сургалт зохион байгуулж туршлага солилцлоо.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Эрүүл мэндийн төвд 60 өвчтөн хэвтэж үүнээс 36-н хүүхэд хэвтэн эмчлүүлж байна.

Эмнэлгийн үйлчилгээ нь:

- Амбулаторийн үзлэг – 126
- Урьдчилан сэргийлэх- 70

- Дуудлага-141
- Нас баралт - 1

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний материал, эм тариа хүрэлцээтэй байна.

“Иргэн төвтэй Эрүүл мэнд өдөрлөг”-ийг аймгийн нэгдсэн эмнэлэгтай хамтран 2019 оны 01-р сарын 30-ны өдөр зохион байгуулж нарийн мэргэжлийн эмч нарын ЭХО, дотор ахмад, хүүхэд, мэдрэл, мэс засал, шүд, чих хамар хоолой, эмэгтэйчүүд зэрэг үзлэгийг 408 иргэнд хүргэж ажилласан. Мөн энэ үеэр байнгын асаргаа шаардлагатай иргэдийн тодорхойлолтыг хэлэлцэх хурлыг сумандаа зохион байгуулж 10 иргэний тодорхойлолтыг хэлэлцэж сунгалт хийсэн.



3-р цэцэрлэг болон “Бүжинхэн бүл” цэцэрлэгийн 200 гаруй хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, асран хамгаалагч нарт нь томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгууллаа.



Шивээговь сумын эмнэлгийн харъяалалд байдаг 14 ахмад настанд Говьсүмбэр аймгийн нэгдсэн эмнэлэгт оочир дугааргүй үзүүлэх картыг гардуулсан.



“Салхин цэцэг” өвчний тохиолдол илэрсэн 3-р цэцэрлэгийн 2 ангид ариутгал халдваргүйтгэл хийсэн.



УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 22 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 6 иргэнийг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

2-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 6 иргэний материалыг хүлээн авч, 23 иргэнд газар өмчлөлийн гэрчилгээг олгосон.

2-р сард 18 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2019 ОНЫ 02 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	6				6	4	2
Төрсөн эх	2	6				6		6
Бүртгүүлсэн гэр бүл	3	3				3	3	3
Нас баралт	4	1				1	1	-
Цуцалсан гэр бүл	5	-				-	-	-
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс	7	4				4	2	2

шилжин ирсэн								
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	-				-	-	-

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО**

2019.02.22

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2019 оны 02-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 300200022101 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Гэрлэлтийн бүртгэл	2500	1	2500				
2	Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	2500	3	7500	1000	3	3000	
3	Сум доторх шилжилт	1500	5	7500	1000	5	5000	
Дүн		17500			8000			
д/д	Үйлчилгээний нэр төрөл	Үйлчилгээний хураамж 3002000221 30 тоот дансанд	Бүгд		Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд		Бүгд	Тайлбар
		Нэг бүрийн үнэ	Тоо	Нэг бүрийн үнэ	Тоо			
7	Иргэний үнэмлэх	15000	6	90000	3300	6	19800	
Дүн		90000			19800			
Нийлбэр дүн		107500			27800			
Нийт орлогын дүн		135300						

ХӨДӨӨ АЖ АХУЙ

Сумын “Цагаан сар-2019” үзэсгэлэн худалдааг 2019 оны 01-р сарын 23-ны өдөр зохион байгуулж 12 иргэн 12 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээр оролцож нийт 1760000 төгрөгийн орлого олсон байна.



Сумын 3 өрхийн гахайг гадагаш гаргалгүй байранд нь хашиж 48 цаг тутамд 3 гахайн байранд ариутгал халдваргүйжүүлэлт хийж аймгийн онцгой байдлын газарт мэдээллийг хүргэн ажилласан.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ



Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 1-р сарын 23-ны өдрийн 27 тоот тогтоолоор Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинээр байгуулсан. 2019 оны 1-р сарын 25-ны өдөр шинээр томилогдсон зөвлөлийн гишүүдэд “Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрэм” сэдвээр сургалт зохион байгуулан заавар зөвлэмжийг өгч

ажиллаа.

Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу “Цалинтай ээж” хөтөлбөрт хамрагдаж 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн хувийн хэргийг нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай тулгалт хийж 181 эхээс 155 эхэд 7741070 төгрөгийг олгосон.



2018 оны 1-р сарын 21-ээс эхлэн Шинээр “Насны хишиг”-ийн мөнгөн тэтгэмжийг

108 ахмад настанд 8100000 төгрөгийг олгосон байна.

Сумын амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулж 15 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн. Үүнд:

- Асаргааны мөнгөн тэтгэмид Эмнэлгийн хяналтанд байдаг байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэнд олгох мөнгөн тэтгэмжийг Г.Нарантуяа, Н.Цагаан, З.Хонгорзул, Н.Наранцацрал, Л.Отгонсүрэн, Л.Батзул нарт олгохоор шийдвэрлэсэн.
- Байнгын асаргаа шаардлагатай 16-аас дээш насны иргэнд олгох амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг Д.Мөнхтулга, Б.Баяртогтох, Б.Батсумъяа нарт,
- Байнгын асаргаа шаардлагатай 16-аас дээш насны иргэнд олгох амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг Н.Гэлэнхүү, Н.Оюунтунгалаг, Д.Мөнхтулга, Ч.Дагвадорж, Г.Манлай нарт
- Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүнд олгох онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжийг Алтангэрэл овогтой Нандинцэцэгт шинээр олгохоор тус тус шийдвэрлэсэн.

Эхийн алдарт 1-р одонтой 63 эхэд 12600000 төгрөг, 2-р одонтой 147 эхэд 14700000 төгрөгийг олгосон.

БАЙГАЛЬ ОРЧИН

Бүх нийтийн их цэвэрлэгээг 2019 оны 01-р сарын 31-ний өдөр зохион байгуулж давхардсан тоогоор 18 аж ахуйн нэгж байгууллагын 173 иргэн 45га талбайн 60 тн хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан.



Мөн энэ өдөр “Страто” ХХК-иас техник хэрэгсэл авч зүүн болон урд гэр байранд хуримтлагдсан 4,5 га талбайн 120 м3 хур хог хаягдлыг түрж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан.



Албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хог хаягдлын хураамжийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж орон нутгийн орлогод 1138000 төгрөг төвлөрөөд байна.

Мэдээ гаргасан:

НЗЭЗАХМэргэжилтэн

О.БОЛОРМАА